

**ҮАГазраас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Мэргэжлийн
боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн
албан шаардлагын биелэлт**

2018.06.30

№	Албан шаардлагын утга	Албан шаардлагын биелэлт
1	<p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 12 ний өдрийн А/234 тушаалаар хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж танхимын түрээсэнд 0,7 сая төгрөг, хоолны зардалд 8,5 сая төгрөг, хулдаасан хэвлэлд 0,02 сая төгрөг, урилга хэвлүүлэхэд 0,2 сая төгрөг нийт 9,6 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх" гэж заасныг үндэслэн дээрх зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй ажиллах.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг 2018 онд зориулалт бусаар зарцуулаагүй бөгөөд, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийг чанд мөрдөж ажиллаж байна. 2. Тус сангаас сургалт, семинар, эрдэм шинжилгээний бага хурлын зардлыг санхүүжүүлээгүй бөгөөд зөвхөн МСҮТөвүүдийн хувьсах зардлыг цаг хугацаанд нь олгож байгаа ба албан шаардлагаар өгсөн заалтыг бүрэн биелүүлж ажилласан болно.

Биелэлт гаргасан: Ахлах мэргэжилтэн



Д.Билэгмаа